

МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД

ТОМООХОН АЖЛУУДААС



Газрын гүний дулаанаар сургуулийн байр халж байна



"Гэр дулаан бол сэтгэл дулаан" төслийн нээлт. 2000 орчим өрхөд нүүрс олгов.



Сум бүрт таван худаг гаргав



Хөшигийн хөндий дэх Чингис Хаан олон улсын нисэх буудлын бүтээн байгуулалтын ажил ид өрнөж байна




Зуунмод суманд 20, 38 айлын орон сууц, хуульчдын хотхоны хөрөнгө оруулалтыг шийдвэрлэснээр ирээдийг орчин үеийн тохилог орон сууцар хангах ажлын эхэлэлийг тавьсан



Малжуулах төслийн хүрээнд 260 өрх хамрагдлаа



2006.3.28-нд Япон улсын Ерөнхий сайдтай Хөшигийн хөндийн нисэх буудлын тухай гэрээ үзүүлэв



Спортын ордон, Зуунмод сум



27 сумын сургуулиудад шатрын танхим байгуулав



Батсүмбэр сум, авто замын нээлт дээр



Зуунмод-Налайх авто замын нээлт



Төв нутгийнхны хүснэгтээдэг "Алтан шанага" наадам



Ахмадын сувилал



МОНГОЛ
АРДЫН НАМ
— 2016 —

БИЛ ЗҮТГЭНЭ ХАМТДАА ХӨГЖИНЕ



МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД

УИХ-ЫН СОНГУУЛИЙН 28 ДУГААР ТОЙРОГТ
Монгол Ардын Намаас нэр дэвшигч

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм сонгогч

Танаа

Төв сайхан нутгийн минь түмэн олон та бүхэн хавар цагийг ханагар давж дэлгэр сайхан зусаж байна уу.

Миний бие төрөлх нутгийн иргэд та бүхнийхээ итгэлийг хүлээж төрд төлөөлөн найман жилийг ардаа орхилоо. Өнгөрсөн он жилүүдэд таны итгэл найдвар, санаа оноо, төрийн тушээ миний санаачилга, зүтгэл, хариуцлага, үүргийн хүрээнд олон асуудлыг шийдэж, олон ажил хийгдсэн. Мөн улс орны нийгэм, эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан зарим бодож төлөвлөж байсан ажлууд дутуу байгааг ч хэлэх нь зүйтэй болов уу.

Тиймээс Та бүхэнтэйгээ энэ удаад би хийсэн ажил, хэрэгжүүлсэн үйлстэй мөн цаашид хийх ажил, бүтээх зорилттой мэндчилж байгаадаа сэтгэл ханамжтай байна.

Он цагийн уртад тасралтгүй үргэлжилсэн харилцаа болон нөхөрлөлийн үнэ цэнэ, утга учир нь ИТГЭЛ гэж би ойлгодог.

Тулгарсан асуудал бүрт тохирсон гарцыг хайн олж бодит ажил хэрэг, үйлс бүтээхийн утга учрыг би хувь хүний ЗҮТГЭЛ гэж сайшаадаг.

Тэгэхээр Төв аймгийн өнгөрсөн, одоо, ирээдүйн Төрийн түшээгээс хамааран шийдэгдэх асуудлууд та бидний итгэл-зүтгэлийн харилцаатай салшгүй холбоотой юм.

Та бүхний мэлмий тунгалаг, өлмий бат оршиж уужим сэтгэлтэй, ухааны цартай, тэгш дүүрэн жаргалтай байхын өлзийтэй ерөөлийг өргөе.

УИХ-ын сонгуулийн 28 дугаар тойрогот нэр дэвшигч, Монгол Ардын Намын дарга



Боржигон овогт
Миеэгомбын ЭНХБОЛД

БИДНИЙ МЭДЭХ, МЭДЭХГҮЙ М.ЭНХБОЛД

► ЭЦГИЙН ГАЛБИР

М.Энхболдын эцэг Миеэгомбо гуай бол нутаг орондоо төдийгүй улс эх орондоо нэр алдраа дуурсгасан эрдэмтэн, багш хүн байсан. Хүнийхээ хувьд ч эгэлгүй нэгэн явжээ. Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав нэгэнтээ “Эцгийг нь муулж байгаа хүнийг би өдий болтол дуулаагүй. М.Энхболд бол тэр чигэрээ эцгийн галбир” гэж дурссан.

► ХОЁР ЭЭЖТЭЙ БОЛСОН НЬ

М.Энхболд хоёр ээжийн мээм зэрэг хөхсөн хүн. Ийм тохиолдол олонгүй. Ерөнхий сайд асан П.Жасрай гуай “Энхболд золиг түрүүлж хөхсөөр байгаад хүү минь (Ж.Жанцан) ийм жижигхэн болчихсон юм” гэдэг байж. П.Жасрай, Миеэгомбо гуай хоёр анд нөхөд байсан. П.Жасрай гуайг бурхан болсныг нь сонсоод хурлын индэр дээр байсан М.Энхболдын царай хувьсхийж байсан гэдэг. Даанч удалгүй Жанцан хүүг нь араас нь явахад, мөөмийг нь хувааж өссөн ээжийнхээ царайг эгцлэн харж чадахгүй бэргэж байсан тухай дотны хүмүүс нь ярьдаг.

► ААВЫНХАА МӨРӨӨДЛИЙГ БУС МЭРГЭЖЛИЙГ ӨВЛӨВ

Эрдэмтэн, багш Г.Миеэгомбо хүүгээ нисэгч болно гэж мөрөөдөж байв. Харин цаг зав л гарвал хөдөө авгууд руугаа морь унахаар яардаг хүү нь нисэгч бус аавынхаа ажлыг өвлөж төлөвлөгч-эдийн засагч мэргэжил эзэмшсэн. Тэр оюунлаг, шинжлэх ухаанч гэр бүлд өсөж хүмүүжсэн.

► “ЧАНГА” ХҮНИЙ УДАМ

М.Энхболдын эмэг эхийнх нь тухай нэгэн сонин түүх. “Эмэг эх Дуламынх нь амны ганц дуу нь “Эр бор харцага” байж. Тэр хэтийдсэн холын бодолтой, шазруун, өөрийн гэсэн гүн ухаантай, эршүүд хүүхэн байж гэж төсөөлөгдсөн. Ямар дуулах дуу мундсан биш дээ, бүсгүй амьтан өөрийгөө дөгөөж, аархаж явжээ дээ. Тийм л “нодготой” хүний үр удмаас цахиур хагалах “юм” төрдөг нь жам” хэмээн нэрт найрагч Ц.Хулан бичжээ.

► ХАМГИЙН ЗАЛУУ ХОТЫН ДАРГА

М.Энхболд хотын хамгийн залуу дарга болсон бөгөөд 35 насандaa энэ хариуцлагатай албан тушаалд томилогдож, зургаан жил



нэр хүндтэйгээр хашсан. 1999 оны 4 дүгээр сард дэлхийн 100 гаруй орны нийслэл хотын дарга нар ОХУ-ын нийслэлд шинэ мянганы чуулга уулзалтад хуран цугласан үед тухайн уеийн Москва хотын дарга Лужков М.Энхболдыг хамгийн залуу мэр хэмээн түүнийг үнэлэн “Москва” хорооллыг бэлэглэж байжээ. Тэгээд өөрийн нэгдүгээр орлогч Ресинд хандан зүгээр нэг “коробка” барихгүй шүү хэмээж байсан гэдэг.

► М.ЭНХБОЛДЫН ХАМГИЙН, ХАМГИЙН

М.Энхболд бол Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын даргын албыг хамгийн удаан (57 сар) хашсан хүн. Мөн Үндэсний Их Баяр наадмын зохион байгуулах хорооны даргаар хамгийн олон жил (11 жил) ажилласан юм. Энэ үед нийслэл хотын авто замын түгжрэлээс үүдсэн хүндрэлээс гарахын тулд наадамчин олны ая тухыг бодон хурдан морины уралдааныг Яармагийн дэнжкээс Хүй мандлын дэнж рүү шилжүүлэх шийдвэр гаргасан. Түүх сөхөхөд 1778-1922 он хүртэл Даншиг наадам, Арван засгийн наадам зэрэг томоохон наадмууд Хүй Мандлын дэнжид болдог байж. Ардын хувьсгал ялсны дараа жанжин Д.Сүхбаатарын 1922 оны 30 дугаар тушаалаар Цэргийн наадмыг Яармагийн дэнжид зохион байгуулж эхэлсэн гэдэг.

► БАРГИЙН ЮМАНД УУРЛАХГҮЙ

Тэр хүний үгийг сайн сонсоно, олон талаас нь бодно. Мөн маш сайн үншина. Хүн хүнээс давуу нэг онцлог нь баргийн юманд уураад байдаггүй. С.Баяр “Залуу хүн гэхэд их тэвчээртэй юм” гэж улс төрд хөл тавиад удаагүй байхад нь хэлж байсан гэдэг.

**ХЭН НЭГНИЙГ
БУРУУТГАХААС
ИЛҮҮТЭЙ АЛСЫН
ХАРААТАЙ
БОДЛОГО
ГАРГАЖ ТАВИХ
НЬ МОНГОЛ
ТӨРИЙН ӨМНӨ
ТУЛГАРААД
БАЙНА...**



“ХҮНЭЭ ОРХИЖ МӨНГӨ ХЭТ ШУТСЭН 25 ЖИЛИЙН АЛДААГАА ЗАСЬЯ”

► ОРОЙ УНТАЖ, ЭРТ СЭРНЭ

М.Энхболдын ажлын нэг том арга барил бол цагийг маш нарийн баримтална. “Шадар сайд ороод суучихлаа. Та нарыг урьж байна” хэмээн тухайн үеийн сайд, гишүүд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрынхныг “бажгадуулдаг” байсан гэдэг. Мөн маш эртэч хүн. Орой унтаж, эрт сэрнэ. Эрт босдог нь тэр өдрийн ажлөө төлөвлөж, бэлдэж байгаатай холбоотой хэмээн зөвлөхүүд нь ярина лээ.

► ОЙ САЙТАЙГААРАА ГАЙХАГДДАГ

М.Энхболд ой сайтайгаараа онцгой гайхагддаг. Гадаад яамны Ёслолын албаныhan “Энхболд дарга хэлэхэд хэцүү гадаад хүний нэрийг хүртэл ямар ч алдаагүй тогтоосон



байхаас гадна тээр олон жилийн дараа хэлж байдаг нь ёстой гайхалтай хэрэг шүү” хэмээн хэлж байлаа. Эдийн засагч мэргэжлийн онцлог болоод ч тэр үү хэлэх үгээ алгын чинээ цаасан дээр тоогоор (кодолж) тэмдэглэдэг.

► ҮНЭНЧ, САЙН НАЙЗ

М.Энхболдын хувьд ажил, амьдралын өгсөж уруудахын аль ч цагт хамт байдаг нөхөд гэдэг юугаар ч оруулж болшгүй үнэтэй. Төрийн ямар ч шатны дарга даамал хийж байсан хуучин хамт ажиллаж байсан, нөхөрлөж явсан нөхдөө хаяхгүй зууралдаад л байдаг зантай.

► МУУ САНАДАГГҮЙ САЙН ЧАНАРТАЙ

М.Энхболд хэзээ ч хэн нэгэнд муу санадаггүй сайн чанартай. Заримдаа төрийн том алба хашиж байгаа хүн гэхэд арай ч дээ гэмээр хүлцэнгүй хандах нь бий. Элдвээр мөн ч их хэлүүлсэн дээ. Тэгэх тусам улам л зөвлөн, ууч болоод байх шиг.

► ТӨВ САЙХАН НУТГИЙН ЗӨВ САЙХАН ХҮН

М.Энхболд тэвчээртэй. “Байр сууриа илэрхийлэх зүйл дээр илэрхийлж, тэвчих зүйл дээрээ тэвчиж тухайн асуудалд, цаг үед нь тааруулж ажиллах ёстой” гэж тэрбээр ярьдаг. УИХ-ын гишүүн, Далай даян дархан аварга Б.Бат-Эрдэнэ “Төв сайхан нутгийн зөв сайн хүмүүн” хэмээсэн.

► ШУУРХАЙ БОДИТОЙ ШИЙДВЭР ГАРГАДАГ

Түүний тэргүүлэн ажилласан Үндэсний эв нэгдлийн Засгийн газар өөр өөр үзэл бодол бүхий таван намын дарга нараас бүрдэж байсан бөгөөд улс орны хэмжээний чухал асуудлуудыг шийдвэрлэх үед гол гарсан хурцхан маргаан үе өرنөдөг байжээ. Тухайн үед аливаад М.Энхболдын хүлээцтэй, тэвчээртэй, тайван зан чанар, шуурхай бодитой шийдвэр гаргадаг шийдэмгийн чадварын ачаар нийгэм, ард олны аж амьдралыг дээшлүүлсэн олон арга хэмжээ авч чадсан.

► ЭРХ МЭДЛИЙГ БҮРЭН ӨГДӨГ

Тэрбээр хажууд нь байхад халгамаар нэгэнтэй ч хамтарч ажиллаж чаддаг онцлогтой. Хүнээр ажил хийлгэж чаддаг. Эрх мэдлийг бүрэн дүүрэн өгнө. Үүрэг даалгавраа хугацаандaa авахаар дор ажилладаг хүмүүсээ “шахдаг”. Заримдаа уг хэлээрээ шахахгүй. “Харц нь үүрэг хариуцлагаа нэхжэй байгаа нь мэдэгддэг” гэнэ.



ТУШЭЭ БАРИМТ

ТУРШЛАГА. М.Энхболдын тэргүүлсэн Үндэсний эв нэгдлийн Засгийн газар цалин тэтгэврийг гурав дахин нэмэгдүүлж түүхэнд тэмдэглэгдсэн. Түүний Засгийн газар гадаад зах зээлээс нэг ч долларын зээл аваагүй, ер тавиагүй гавьяатай.

ТООЦООЛОЛ. 2008 оны Бээжингийн олимпийн бэлтгэл ажлын хүрээнд олимпийн багийн төсвийн хөрөнгийг 10 дахин, тамирчдын цалин хангамжийг 7 дахин нэмэхийн зэрэгцээ хэрэгтэй бүхий л санхүүжилтийг босгож чадсан.

МАНЛАЙЛАЛ. М.Энхболд 2003 оныг Их бүтээн байгуулалтын жил болгон зарлаж өөрөө манлайллан оролцсон. Ганцхан жишээ, 60 жил гар хүрээгүй Д.Сүхбаатарын талбайн 32 мянган м² талбайг боржин чулуугаар бурсэн.

ХАРАМСАЛ. Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Оюутолгойн гэрээний төслийг боловсруулж УИХ-д өргөн барьсан ч ажлын хэсэг хөдлөхгүй байсаар дараагийн ЗГ-ын шинэ гэрээ орж ирсэн. Монгол улс 34 хувия үнэгүй авах, хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2.7 тэрбум доллар гэх мэт их ашигтай гэрээг батлууж чадаагүйд тэр харамсаж явдаг.

ЗАНГАРAG. МАН-ын дарга М.Энхболдын санаачилгаар улс төрийн 22 нам үндэсний зөвшилцлийн уулзалт хийлээ. Улс орны хэмжээнд тулгамдсан асуудлыг хамтдаа хэлэлцдэг үндэсний зөвшилцлийн асуудлыг МАН анх санаачилж 27 дугаар их хурлаараа уриалга гаргасан.

НАЙДВАР. Аливаа улс орны төвд ойр байгаа муж, хот, тосгон нийслэлийнхээ хүнс тэжээл, хангамжийг хариуцаж байж хөгждэг жамтай. М.Энхболд даргын суурийг нь тавьсан Хөшигийн хөндийн нисэх буудлыг дагаж 100.000 хүнтэй дагуул хот бий болно. Тэрээр олон улсын өмнө үүрэг хүлээсэн энэ төслийн баттай суурь нь Төв аймагчууд байж хөгжинө гэдэгт найддаг.

ЭМЗЭГЛЭЛ. Тэрбээр сүүлийн жилүүдэд эдийн засаг, улс төр ярьсаар хувь хүний асуудлыг орхигдуулсанд эмзэглэдгээ хэлсэн. Мөн ахмад үеэ халамжлан анхаарахад санаа зовниж өндөр насалсны тэтгэмж олгох, Ач санах хуулийг батлуулахыг зорьж яваа.

БАХАРХАЛ. Монгол улсын шинжлэх ухааны академийн тэргүүлэгч гишүүнээр найм дахь жилдээ ажиллаж байгаа тэрбээр Ерөнхий

сайд байхдаа шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, бүхий л салбарт инновацийг хөхүүлэн дэмжих байв. Тэр оюуны хөдөлмөрийг даацтайхан үнэлж, шийдвэр гаргаж чаддаг. Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, шатрын их хорхойтон Ж.Самбуу агсны 120 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Төв аймгийн 27 сумын бүх сургуульд шатрын танхим байгуулж өгчээ.

ОМОГШИЛ. 1964 оны луу жилтнүүд гэж Монгол бөхийн зүлэг ногоон дэвжээн дээр алдартай нэгэн үе байх. МУ-ын дархан аварга Б.Бат-Эрдэнэ, улсын арслан Д.Мөнх-Эрдэнэ, улсын гарыд П.Сүхбат гээд л. М.Энхболд дарга зүлэг ногоон дэвжээн дээр зодоглоогүй ч улс төрийн дэвжээн дээр дархан аварга. Ардын уран зохиолч Б.Догмид гуай “Богд хан Дүнжингарав уулын ар дээр ч, өвөр дээр ч босоо чигээрээ олны итгэлийг дааж яваа төрийн дархан түшээ” хэмээсэн байдаг.

ИТГЭЛ. Улаанбаатар хотоос нэг удаа, Төв аймгаас хоёр удаа УИХ-д сонгогдсон, МУ-ын 24 дэх Ерөнхий сайд, Шадар сайдаар хоёр удаа, МАН-ын даргаар хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж буй хал үзэж, хат суусан мэргэшсэн улс төрч. ■

М.ЭНХБОЛД: ТӨР ЗАСАГ БОЛ ТҮМЭН ОЛНЫХОО АМЬДРАЛЬН ТӨЛӨӨ Л АЖИЛЛАХ ЁСТОЙ

УИХ-ЫН дэд дарга, МАН-ЫН дарга М.Энхболдтой ярилцлаа.

Та сайхан зусч байна уу. Намын даргын хувьд сонгуульд намаа удирдаж оролцоно, өөрөө Төв аймагтаа нэр дэвшиж байгаа гээд Таны хувьд маш завгүй өдрийд эхэлж байна?

Улс орон даяар л УИХ болон орон нутгийн сонгуулийн сурталчилгаа эхэллээ. Манай намын хувьд 2013 оноос сонгуулийн бэлтгэл ажлыг хангах комисс ажиллаж эхэлсэн. Бүх зүйл төлөвлөсөн ёсоороо явж байна. Энэ жил манай нам харьцангуй залуу хүмүүсийг нэр дэвшүүлэх бодлого барьсан. Хамгийн залуу нэр дэвшигч 29 настай байх жишээтэй. Зо гаруй хүн анх удаагаа УИХ-д шинээр нэр дэвшиж байна. Гараа сайн бол бария сайн гэдэг. Ажил эхэлж байх үедээ цэгцтэй, журамтай, хүмүүст тодорхой ойлгогдохоор байх нь их чухал. Том ажил эхлэхийн өмнө эргэж буцсан, будилж мунгинасан байдал ажлын эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлдөг. Энэ бол зөвхөн улстөрийн сонгуульд ч биш хүний амьдралын янз бүрийн асуудлуудад, төр засгийн ажилд ч хамаатай.

Би өөрөө Төв аймагтаа нэр дэвшиж байгаа. Өмнө нь би можаритор тойргоос нэр дэвшин сонгогдож байсан. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд юу хийсэн талаарх тайлангаа аймгийн ард иргэддээ тавиад ирсэн. Сонгогчид биднийг олонх болж чадаагүй ч сөрөг хүчний хувьд, барагчийг зүйлийг хийлээ гэсэн үнэлэлт дүгнэлт өгч байгаа. Нэгд, аймаг орон нутагт хийсэн ажил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг үнэлж байна. Хоёрт, МАН-ыг өнгөрсөн дөрвөн жилийн сөрөг хүчний үйл ажиллагаагаар нь үнэлж байна. Сөрөг хүчний үйл ажиллагааг хангальттай гэж Төв аймгийнхан маань үнэлжээ.

Төв аймгийнхан маань хатуу өвлийг хэр давав даа. Одоо зүншлага ямархуу байна?

Дэлгэр сайхан зүн болж олон түмэн олон сэтгэл тайвуу улс төрийн сонголтоо хийж, үндэсний их баяр наадмаа өргөн дэлгэр тэмдэглэх байх гэж бодож байна. Хавар хэд хэдэн удаа цас орсон. Хаврын цасыг шар тос гэж монголчууд эртнээс ярьдаг. Гэхдээ манай аймгийн хувьд энэ цас алаг цоог оржээ. Зарим суманд зүншлага сайхан эхэлсэн. Заримд нь төдийлөн санасан

хэмжээнд ногоо гараагүй байгаа. Гэхдээ дэлгэр сайхан зүн болж, хадлан бэлтгэх, малаа таргалуулах, тариа будаа хураах гээд намрын их ажил цаг хугацаандаа амжиж бүтээмжтэй байх гэж бодож байна.

Хот суурин газартай ойр байдаг болохоор сүүсааль, хонь ямаагаа зарахаас эхлээд Төв аймгийнхан зах зээлд их эрт орсон санагддаг. Гэхдээ л сүү саалица борлуулахад бэрхшээл учирдаг хэвээр. Биднийг "Шанага нь тав" гэж ч хочилдог. Харин эдийн засгийн хямралд нутгийнхан маань хэр барьц алдаж байна вэ. Сонгогчид танд энэ талаар ярьж л байгаа байлгүй?

"Шанага нь тав" гэж манай аймгийнхныг хэлцгээж л байдаг. Гэхдээ одоо "шанага нь таван төгрөгийн үнэтэй" юу ч байхгүй болсон. Бүх юмны үнэ асар их өссөн. Ялангуяа сүүлийн дөрвөн жилд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ хоёр тийшээ явчихсан. Хүнсний бүтээгдэхүүний үнэ дунджаар бо орчим хувь өсчээ. Цалин ердөө наймхан хувь нэмэгдсэн. Дөрвөн жилийн дотор шүү дээ. Тун харамсалтай. Эрх баригчид цалин тэтгэврийг 8-10 хувь л нэмлээ. Уг нь инфляци, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт ард иргэдийн амьдралд хэр хүнд тусч байна гэдгээс шалтгаалан цалин хөлсийг түүнээс дутахгүй хэмжээнд нэмж явах ёстой. Гэтэл өнгөрсөн дөрвөн жилд өмнөх Засгийн газруудаас уламжлан ирсэн энэ туршлага алга боллоо.

Манай Төв аймгийнхан бол хэзэнээсээ Улаанбаатар хотын ар тал болж ирсэн ард түмэн. Хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээний хувьд Улаанбаатарчуудын ар талыг хангаж тэтгэж ирсэн. Гэхдээ үүнийг төрөөс зохицуулж, тодорхой хэмжээний дэмжлэг өгөх ёстой. Жишээ нь, хоёр гуравхан жилийн өмнө улсын хэмжээнд ургацын 30 орчим хувийг Төв аймгийнхан хурааж авч байсан. 100 гаруй мянган тонн улаан буудай хураан авч байлаа. Гэтэл өнөөдөр энэ үзүүлэлт хэд дахин буурчээ. Төрөөс заавал дэмжлэг үзүүлж байж хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл амжилттай хөгжих ёстой. Тариаланчдад гурилын үйлдвэрт тушаасан улаанбуудайн хэмжээгээр төрөөс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог би Ерөнхий сайд байхдаа анх бий болгосон. Үүнтэй адилхан мах,





сүүнд ч төрөөс анхаарч дэмжлэг үзүүлэх ёстай. Ингэж чадвал Төв аймгийнхан маань сайхан амьдрал боломж бололцоо бүрдэнэ. Өнгөрсөн жилүүдэд арьс шир, ноос ноолуур үйлдвэрлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлсэнгүй. Мал аж ахуйн гаралтай түүхий эд хамгийн хямд үнээр зах зээлд нийлүүлэгдэж байна. Энэ бүхэн малчдын амьдралд сөргөөр нөлөөлж байна. Би сая тайллан уулзалт хийх үеэрээ аймгийн төв, сумын худалдаа үйлчилгээний газруудаар орж асуулаа. Нэгдүгээрт, хүн амын худалдан авах чадвар маш их буурсан гэж худалдаа эрхлэгчид ярьж байна. Хоёрт, хүссэн хүсээгүй бид барааны үнээ нэмэх болж байна гэсэн. Үүний цаанаа иргэдийн худалдан авах чадвар муудсан, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс бүгд өр зээлийн барьцаанд орсон, иргэд амьжиргаагаа авч явах боломж багассан гэдэг нь харагдаж байна.

Хямрал гэснээс их олон айл таны тус дэмээр мал малын захтай болж сайхан амьдарч яваа. Би өөрөө Баянцогтын хүүхэд болохоор үүнийг сайн мэдэж байна л даа. Малжуулах хөтөлбөрийн үр дүнгээ та дүгнэж үзэв үү?

2009-2010 онд Улсын хэмжээнд айхтар зүд болон зуун өрх айл малаа ихээр хорогдуулж, амьжиргааны эх үүсвэргүй болсон учраас Улсын хэмжээнд малжуулах төсөл хэрэгжүүлсэн. Би өөрийн сонгогдсон тойротгоо малжуулах төслийг мөн хэрэгжүүлж байлаа. Миний удирддаг “Эх нутгийн иргэд” төрийн бус байгууллагаар дамжуулан нэг айлд 10 охин төлөг, долоон охин борлон өгсөн. Үүнийгээ тухайн сумын олон малтай айлаас худалдаж авч өгсөн. Ингэснээр зарим айл нь малаа худалдаж мөнгөтэй болсон бол зарим нь малтай болсон. Нийт 260 орчим өрх хамрагдсан. Үүний үр дүнд мал хүйтэй болж, амьжиргаагаа авч яваа олон айл байна. Тойротгоо ажиллаж байхад таны ачаар малтай болж, миний амьдралд өөрчлөлт гарсан гээд баярлаж талархсанаа хэлэх хүмүүс таарч байдаг. Цашид мал аж ахуйн салбарыг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэгт бодож төлөвлөсөн олон асуудлыг бид мөрийн хөтөлбөртөө тусгасан. Мал аж ахуй, газар тариалангийн салбар бол Монгол Улсын ирээдүйн хөгжлийн гарц гэж би боддог.

Баянцогтын харьят Монгол Улсын гавьяат малчин, алдарт уяач Бандийн Дэмбээ бол миний аав. Нэг удаа хөдөө гэртээ байж байтал Таны бие төлөөлөгч гээд машинтай хүмүүс ирлээ. Тэд таны санаачилгаар хэрэгжүүлж байгаа малжуулах хөтөлбөрийн тухай ярьж, ааваас баахан хонь, ямаа худалдаж аваад нутгийн 10 гаруй айлд бэлэглэж байж билээ. Малаа авах гэсэн хүмүүс машинтай, морьтой гэр бүлээрээ цргээж, наир наадам шиг л баяртай үйл явдал болж байсан шуу. Хүнийг ингэж баярлуулах бас сайхан юмаа гэж бодож байлаа...

Би өөрийг чинь хэлэхээр санах байна. Танай аавыг би сайн таних юм байна. Бид адилхан өөрсдийн сонирхол, дур хүслээрээ морь уяж, ярьж хөөрч явлаа. Би Баянцогтод очих бүртээ танай аавтай уулздаг байлаа. “Энэ жилийн наадам ямар болох нь вэ. Энхболдоо, наадмын бэлтгэл юу болж байна” гээд энгийн сайхан яриа хөөрөөтэй манай нутгийн сайхан

өвгөн байсан. Уясан морь нь сайхан хурдалж, олон түмэнд нэр цуу нь алдаршсан сайхан хүн байсан юм.

Боломж бололцоо байдаг бол хүнд буян хийж, тус болж явах шиг сайхан юм байдаггүй. Буян хийсэн хүн хариуг нь заавал хүртдэг, эдэлдэг шиг байгаа юм. Тийм учраас би боломж бололцоотой үедээ нутгийнхаа төдийгүй улсын хэмжээнд амьдралын боломж тааруу хүмүүсийг дэмжих, туслах арга хэмжээг заавал авах ёстой гэж үздэг. Ер нь төр гэж байдаг бол түмэн олныхоо амьдралын төлөө л байх ёстой. Би тэтгэвэр, тэтгэмжийг гурав дахин нэмсэн. Хавтгайран халамжийн улс орон болгочихлоо гэж намайг шүүмжилж байсан үе саяхан. Гэхдээ би түүнд ердөөсөө эмзэглэдэггүй. Би “Үйдийн цай” хөтөлбөрийг анх удаагаа хэрэгжүүлсэн. Монголын хүүхдүүдэд Хүүхдийн мөнгө олгох ажлыг би гардан зохион байгуулж байсан. Ингэж хүмүүсийн амьдралд тусалсан нь төр засаг хийх ёстой ажлаа л хийсэн гэж боддог.

Манай нутгийн хөгжлийг цуглахаараа ярьдаг нэг сэдэвтэй болжээ. Энэ нь ахмадын амралтын тухай. “Хөнгөлттэй үнээр амардаг, эмчилгээ сайтай, ноднин амарсан. Энэ жил дахиад амарнаа” гэцгээж байна. Тээх нь ээ, таны санаачилгаар байгуулагдсан амралт, сувилаалт гэх юм?

Ахмадуудыг асарч сувилааг сувиллын газар аймагтаа байгуульяа гэдэг санал оруулж хөрөнгө мөнгийг нь шийдүүлээд 2013 онд ашиглалтад оруулсан. Нийгмийн даатгалын сангаас амралтын зардлын тодорхой хувийг ахмадууддаа буцаан олгож байгаа. Богд уулын Баруун Зуун модны ам гээд сайхан газар байгуулагдсан сувилаал. зо ортой, халаалт дулаантай, ажиллах амрах бүх нөхцөл нь бүрдсэн ийм амралтыг аймгийнхаа ахмадуудад зориулан байгуулсан. Зөвхөн өнгөрсөн зүн, намар л гэхэд 250 ахмад аймгийн төв болон сум сумаас ирж амарсан байна лээ. Ахмадууд маань ам сайтай байгаа. “Сайхан амарч тэнхэрлээ, хоол унд, үйлчилгээ сайтай юм” гэж магтаж байгаад нь би баяртай байгаа.

Малчдын хувьд худаг усны асуудал маш чухал байдаг. Харин та тэр асуудалд анхаарлаа хандуулж сумдад их олон худаг гаргаж өгчээ. Манай суманд ч хэд хэдэн худаг гаргаж өгсөнд малчид их ам сайтай байдаг. Танд ийм хүсэлт байнга ирдээ үү?



Олон жилийн өмнө дөө, намайг Улаанбаатар хотын захирагчаар ажиллаж байхад Сөүл хотын дарга “Усыг удирдаж чадсан хүн их удирдагч болдог юм шүү” гэж хэлж байсан юм. Гал, ус бол юуг чөөртөө халдаадаггүй, бүгдийг дийлдэг гэдэг. Тийм болохоор усыг удирдана гэж юу байхав. Би энэ үгийг “хүнд усыг хэрэгцээ, хэрэглээнд зориулж хүргэх нь зөв юм байна” гэж тайлж боддог. Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа улсын хэмжээд инженерийн хийцтэй гүний 2200 гаруй худаг гаргасан. Тэр хоёр жилийн хугацаанд гаргасан худгийн тоогоороо социализмын үеийнхтэй ойролцоо очих байх. Ийм хэмжээний худаг гаргах бодлого барьж байсан Засгийн газар өөр байгаагүй. Сүүлд өөрийн сонгогдсон тойрог, орон нутагтаа энэ бодлогоо хэрэгжүүлэх ёстой гэж үзээд. Төв аймгийн хэмжээнд 130 гаруй худаг гаргасан байна. Худаг ус гаргаж өгнө гэдэг хүний амьдралын хувьд тодорхой үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, амьдрал ахуйгаа авч явах боломж бололцоо олгож байгаа хэрэг. Цаашдаа ч худаг усны асуудалд анхаарна.

Нэг үеэ бодвол хотоос төв аймгийн төв рүү хэдхээн минут давхиад хүрчихдэг болж. Бас зарим сумдын замыг хоттой холбоод сайхан болгочихож. Таны Ерөнхий сайд байхдаа анх гэрээ үзэглэж байсан Хөшигийн хөндийн онгоцны буудал ирэх онд ашиглалтад орно гэх мэтээр Төв аймагтай холбоотой бүтээн байгуулалтууд өрнөж

байна. Та нутгийнхаа хөгжлийн хэтийн төлвийг яаж төсөөлж хардаг вэ?

Төв аймгаас сонгогдсон гишүүд ярьж байгаад хоёр гурван төсөл эхлүүлсэн. Нэгд нь, аймгийн төвийг баруун зүүн хоёр талаар нь Улаанбаатар хоттой холбогддог болгой гээд замын асуудлыг шийдэж байсан. Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах хөтөлбөр төслийн хүрээнд Батсүмбэр, Борнуур, Жаргалант сүмдүг нийслэлтэй засмал замаар холбосон. 2012 оноос Их хуралд сонгогдсон гишүүд орон нутгийн иргэдийн үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнийг аюулгүй тээвэрлэх, хотод хурдан авчрах тал дээр анхаарал тавьж хийсэн ажил. Аймгийн хөгжлийн ирээдүй гэвэл бид эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үр шимээр Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээг хангах бодлогыг барих ёстой. Манай аймгийн нутагт Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны буудал баригдаж байна. Би Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Японы Ерөнхий сайд Коизумитай 2006 оны гуравдугаар сарын 28-ны өдөр уулзаж энэ хүсэлтийг тавьж байсан. Дөрвөн сарын дараа Коизуми Ерөнхий сайд манай улсад айлчлахдаа Хөшигийн хөндийд буудал барихад тусалж хөрөнгө оруулна гэдгээ хэлснээр ажил эхэлсэн. Зуунмод хоттой ойрхон онгоцны буудал баригдвал түүнийг дагасан шинэ хот бий болно, төв аймагчудад ажлын байр бий болж амьдралыг нь өөд нь татах сайхан

боловж бүрдэх юм гэж бодож хийж байсан. Бодож байсан зүйл маань биелж байна. Хэдхэн хоногийн өмнө Сэргэлэн сумын иргэдтэй уулзахад Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудалд нутгийн иргэдээс ажиллуулаад эхэлсэн гэж байна лээ. Яг үүний нэг адил билд аялал жуулчлалын салбарaa хөгжүүлэх ёстай.

Манай хөдөөнийхөн цаг агаараас шууд хамааралтай амьдардаг. Бороо орж, ногоо ургаж сайхан зүн болбол л хүн малын нуруу тэнийдэг. Харин өвөл, хавар, намрын их ажил, ган эзүд гээд махийтал зүтгэх цаг олон. Энэ бүхэн ч нөвлөлдөг байх, залуус гэлтгүй айлууд хот суурин газар руу нүүж байна. Таныхаар яаж хөдөөдөө ая тухтай, ажил төрөлтэй сайхан амьдрах вэ?

Хүний амьдрах орчинг сайжруулах л хамгийн чухал асуудал. Энэ орчныг сайжруулбал аяндаа ажлын байр бий болж хүмүүс хот руу шилжихээ болино. Нөгөө талаар холын алслагдсан аймгуудаас хүмүүс манай аймагт ирж олноор суурьшдаг. Ер нь хүмүүсийн амьжиргаа, нөхцөл байдлыг сайжруулах тал дээр анхаарах ёстай. Байр орон сууцны асуудал хамгийн чухал. Бид зургаа долоон жилийн өмнө 20, мөн 38 айлын орон сууц аймгийн төв дээр барьж байсан. Аймгийн хууль хяналтын байгууллагуудын ажилтнуудын амины орон сууцны хотхоныг байгуулах хөрөнгийг босгох талаар Засгийн газарт байхдаа тодорхой арга хэмжээ авч нийт 80-аад айлын орон сууц барих нөхцөлийг бүрдүүлж байсан. Сүүлийн жилүүдэд 1000 айлын орон сууц хөтөлбөр хэрэгжих эхэлж байна. Хөдөөд аль залуу хүн сайн ажиллан амьдралаа сайхан авч явааг тэр гэхэв. Хамгийн гол нь хүн өөрөө өөрийнхөө мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ ухамсар, сэтгэхүйг өөрчлөх, амьдралын төлөө зүтгэх бололцоогоор хангах, тэднийг сургах, туршлага суулгах хэрэгтэй.

Нутгийн айлуудаар буууж мордож явахад таны зураг, зурагтай сэтгүүлийг их хүндэтгэлтэй хадгалдаг юм билээ. Та үүнийг анзаарч байсан уу?

Нутгийн олон түмэн надад итгэж найдан, нутгаас төрсөн улстөрийн зүтгэлтэн гэж үнэлдэг. Ер нь хэлсэн ярьсан зүйлийг нь хэрэгжүүлэхийн төлөө зүтгэдэг болохоор итгэл хүлээлгэдэг байх. Манай нутгийн

ард түмэн үргэлж л надад итгэл хүлээлгэсээр ирсэн, надаас шинэ шинэ зүйл хийхийг хүсч байдаг. Хөдөө явж байхад таны хэлснээр миний зургийг тавьсан айл байдаг юм. Хүмүүсийн итгэл найдварыг дааж явах шиг сайхан зүйл юу байхав. Улам л итгэлийг нь алдахгүй ажиллах юмсан гэж боддог.

Хөдөө олон хүнтэй уулзаж, олон айлаар орж байсан байх. Сайхан үйл явдал эсвэл гайхалтай сайхан уг хэлсэн хүн ч юм уу санаанд тодхон байдаг дурсамж гэвэл юуг хэлэх вэ?

Манай Төв аймагчууд зан төрхийн хувьд их амар амгалан сайхан хүмүүс байдаг юм. Нутаг орныхоо хүмүүстэй уулзаж учраад явж байхад яриа хөөрөө сайхан нийлдэг. Би бол тэднийхээ төлөөлөл болж УИХ-д ажиллахын зэрэгцээ蒙古 хүн бүрийн сэтгэл зүрхэнд уяатай байдаг хурдны морь уяж, уралдуулах сонирхлоороо хөдөөгийн ард түмэнтэй нам улстөр харгалзахгүй хэнтэй нь ч санаа оноо нийлээд явдаг. Надтай хамт Б.Бат-Эрдэнэ аварга Төв аймагаар явж байхдаа нутгийнханд хандаж “Төв сайхан нутгийн зөв сайхан хүмүүс шүү, та нар” гэж уг хэлж байсан юм. Тэр уулзалт, үйл явдал миний сэтгэлд одоо ч тодхон санагдаж л байдаг юм.

Төв аймгийнхны нийтлэг зан төрх нь их амгалан, уужуу тайван, хүлээцтэй гэж та сая хэллээ. Танаас ч ийм чанар харагддаг. Энэ бусдаас ялгарах давуу зан чанар шиг санагддаг. Та тэгж боддог уу?

Хүн адгаж яарлаа гээд хождоггүй. Бодож байж бууртай суурьтай асуудалд хандвал будилж төөрөхгүй. Миний энэ зан төрх бол аав, ээжээс маань уламжилж ирсэн шиг байгаа юм. Манай аав, ээж Төв аймгийн Баян сумын хүмүүс. Тал нутгийн хүмүүст ийм зан араншин төлөвшиж тогтсоныг үр хүүхэд нь залгаж авсан байх. Одоо миний найз нөхөд, аймаг орон нутгийн хүмүүс бүгд л ийм тайван амгалан зантай шүү. Асуудалд бууртай, бодож болгоож хандахгүй бол “би л дарга хүн, би л асуудал шийддэг” гээд ухасхийж очиж уг хэлээд, хэлсэн уг нь хэрэгжихгүй бол яваандаа тэр хүний нэр хүнд унадаг. “Би л намын дарга, ийм ч хүнийг дэвшүүлэхгүй, тийм ч хүнийг дэвшүүлэхгүй” гэж нийтэд зарлаачиаад дараа нь тэрийгээ ч дэвшүүлээд, энийгээ ч дэвшүүлээд байвал өөрийнх нь л нэр хүнд унана.

МАНЫН ЭНЭ УДААГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ГОЛ ҮЗЭЛ САНАА, УРИАЛГА НЬ ЮУ ВЭ?

Мөрийн хөтөлбөр бол сонгуульд амжилт гаргах нэг том хүчин зүйл гэж ойлгож хандаж ирсэн. Манай мөрийн хөтөлбөр улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн байгаа түвшинд маш үндэслэл сайтай, дүгнэлт хийсэн. Яг энэ гараан дээрээс цаашаа яаж ажиллах вэ гэдгийг бид мөрийн хөтөлбөртөө тусгасан. Манай мөрийн хөтөлбөр хүний амьдралын үе шат бүхэнд зориулагдсан. Эхээс төрж байгаа хүүхдэд ямар халамж анхаарал хэрэгтэй юм, идэр залуу нас, оюутан залуус ажил хөдөлмөр эрхэлж байхад, тэтгэвэрт гарах энэ бүх үе шатанд төрөөс ямар бодлого хэрэгжүүлэх юм, монгол хүнийг яаж тайван амгалан, баян чинээлэг амьдруулах боломж байна вэ гэдэгт чиглэгдсэн. Нөгөөтэйгүүр нийгмийн амьдралын бүхий л салаа мөчир, бизнесийн орчинд эдийн засгийн эргэлт сэргэлт бий болгох зорилготой мөрийн хөтөлбөр. Эхний хоёр жилийн хугацаанд улс орныг урьд байсан хэмжээнд нь хүргэхийн төлөө зүтгэж ажиллах ёстай. Бидний 70 жил зээл авч хийсэн их бүтээн байгуулалтын өр 11 тэрбум доллар байсан. Бид энэ өрийг тэглэсэн. Өнгөрсөн дөрвөн жил тавьсан өр зээл хэрээс хэтэрлээ. Сүүлийн 20 жилд авсан гадаадын зээл, тусlamжийн дунтэй тэнцэхүйц зээлийг дөрөвхөн жилийн дотор авч манай улс нийт 22,0 тэрбум долларын өртэй боллоо. Энэ бол дөнгөж төрсөн нялх хүүхдээс өтгөс буурал хүртэл хүн бүр 15 сая төгрөгийн өртэй боллоо гэсэн уг. Манай улсын зээлжих зэрэглэл хөөрөө буурч, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдлаа. Энэ нөхцөл байдалд бид яаж ажиллах вэ гэдгээ мөрийн хөтөлбөртөө тусгасан. Иргэдээ ядуурлаас яаж аврах, эдийн засгаа хямралаас яаж гаргах вэ, эх орноо өрнөөс яаж салгах, төрийн дамжуулрыг хэрхэн яаж засах, тэгш журамт хүчирхэг Монгол улсаа хэрхэн яаж байгуулах вэ. Үүний төлөө бид хамтдаа зүтгэх ёстай гэсэн гол зорилтыг дэвшүүлсэн. Та бүхэн манай намын мөрийн хөтөлбөртэй сайн танилцаарай. Бид тооцоо судалгаан дээр үндэслэн боловсруулж үндэсний цогц хөтөлбөрөө гаргасан учир хамтдаа өсөж дэвжих бүхий л боломжийг нээсэн байгаа. Та бүхний төрийн сүлд үргэлж ивээж явах болтугай.

Ярилцсан Д.Оюунтуяа

НЭГЭН



АЯЛЫН

ТЭМДЭГЛЭЛ

УИХ-ЫН ГИШҮҮН О.СОДБИЛЭГ:

**М.Энхболд дарга багийн
лидер хүн багтаа хэрхэн ноён
нуруу болж явдгийг өөрийн
биеэр үлгэрлэн харуулсан**







► УИХ-ЫН ГИШҮҮН О.СОДБИЛЭГ: ИРЭЭДҮЙД ХАМТДАА ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ЭРЧ ХҮЧИЙГ ӨГСӨН

М.Энхболд даргатай энэ парламентад бид олон саад бэрхшээлийг давж ажиллаа. Багийн лидер хүн багтаа хэрхэн ноён нуруу болж явдгийг өөрийн биеэр үлгэрлэн харуулсан. Даргыг би залуу сэтгэлгээтэй, эрч хүчтэй хүн гэж боддог. Үүнийг хүмүүс төдийлөн сайн мэддэггүй. МАН өнгөрсөн сонгуульд цөөнх болсон. Энэ үед М.Энхболд дарга нэг л янзаараа байж чадсан нь нөхдөдөө итгэл үнэмшил төрүүлж, ирээдүйд хамтдаа илүү ихийг бүтээх эрч хүчийг өгсөн.

► ДУУЧИН А.ХАЯНХЯРВАА: ЗАЛУУ СЭТГЭЛГЭЭТЭЙ, НОЁН НУРУУТАЙ

МАН-д гишүүнээр элсэхдээ М.Энхболд даргаас намын батлахаа гардан авч байсан. НАМЗХ-нд байхдаа ойр дотно байж, олон жил хамтран ажилласан учир хувь

хүний талаас нь болон улс төрчийнх нь хувьд сайн мэддэг болсон. М.Энхболд дарга бол залуучуудад ээлтэй, тэднийгээ их дэмждэг гэдгээ энэ удаагийн сонгуульд залуучуудыг түлхүү дэвшигүүлснээрээ харууллаа. Залуу сэтгэлгээтэй, мундаг удирдагч. Эр хүн талаасаа ч тулхтай, ноён нуруутай.

► УРТЫН ДУУЧИН Д.ҮҮРИЙНТУЯА: МОНГОЛ УЛАМЖЛАЛАА МАШ ИХ ДЭЭДЭЛДЭГ ХҮН

Олон жил төр нийгмийн алба хашсан, төв сайхан, ноён нуруутай улс төрч гэж боддог. Бид хоёр боржигон нутгийн улс. Хувь хүнийх нь талаас их үнэлсэн нэгэн үйл явдлын талаар ярья. Охиных нь хуrimыг боржигон удмын заншилаараа уртын дуугаар эхэлж, уртын дуугаар өндөрлөсөн. Хүмүүс уртын дуу дуулах хэрэггүй, дуулбал богино дуулаарай гэж хэлдэг болчихсон цаг. Гэтэл М.Энхболд гуай эхлэл дуугаар эхлүүлж "Жаргалтайн

дэлгэр" дуугаар төгсгөсөн. Үүнийг нь хараад би монгол уламжлалаа маш их дээдэлдэг, монгол хүний мэдвэл зохих зүйлийг гаргуун эзэмшсэн хүн байна гэж их баярласан.

► МУГТ Ц.ШАРАВЖАМЦ: ТУУШТАЙ, ТЭВЧЭЭРТЭЙ, АЛСЫН ХАРААТАЙ

Нутгийн ах М.Энхболдыгоо цөөн үгээр илэрхийлбэл даруу төлөв, тууштай, тэвчээртэй, алсын хараатай, хамгийн гол нь сайн удирдагч хүн.

► ДУУЧИН А.ХИШИГДАЛАЙ: ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭЖ ЧАДАХ ХҮН


Монгол Улсын төрийн удирдагч хүн буурь суурьтай, мэдлэгтэй, хүнлэг байх ёстой. М.Энхболд даргад энэ бүх зан чанар бий. Тэрээр төрд олон жил бэлтгэгдсэн, хийсэн бүтээсэн зүйлтэй хүн болохоор учраа мэдэхгүй шинэ хүмүүсийг бодвол илүү ихийг бүтээж чадна. Төрийн дээд байгууллагад түүн шиг хүн л байх ёстой.



“БИ ААВААСАА АСУУЯ...”



Аав Г.Миеэгомбо,
ээж Д.Цэдэв нар
Улаанбаатар 1968 он



Тэд 10 жилийн
нэг ангийхан

ХАРИУЦЛАГАТАЙ АЛБАНД СОНГОГДСОН ЗАЛУУГИЙН АМНААС ГАРСАН АНХНЫ ҮГ “БИ ААВААСАА АСУУЯ”.

Нийтийн Аж Ахуйн яамны мэргэжилтэн 25 настай М.Энхболдыг нэг өдөр дарга нь дуудаж Хотын ахуйн үйлчилгээний хэлтсийн даргаар томилох тухай дуулгав. Хариуцлагатай албандаа сонгогдсон залуугийн амнаас гарсан анхны уг “Би ааваасаа асууя”. Хожмын нэг өдөр хотын дарга М.Энхболд аавыгаа дэргэдээ суулгаад давхиж явахдаа ордны баруун уулзвараар ширүүхэн эргэчихэж. Аав нь “Аажуухан яв. Осол гэдэг хэнд ч тохиолдоно. Хотын дарга гээд биеэ тоогоод байна уу” гэж. 90 жилийн түүхтэй том намын дарга одоо жолооны ард суух бүрдээ аавынхаа энэ үгийг санадаг. Уул шиг бараа сүртэй энэ эрхмийг Г.Миеэгомбо гуай мундаг сайн хүмүүжүүлжээ.

Улс төрийн тогоонд эв зэййг эрхэмлэн идүүлсэн бут ургадгийг тодоор харуулж яваа М.Энхболд даргыг масс МАН гэж

хардаггүй. Учир нь тэр аль ч Засгийн газрын үед бүтээгч, зөв шийдвэрлэгч, гарц хайгч байсаар ирсэн. Эр хүний ноён нуруу нь улс төрийн тэнхээтэй шийдвэр, үйлээр нь илэрдэг. М.Энхболд нийгмийн бүхий л салбарын асуудалд чин сэтгэлээсээ үр бүтээлтэй хандана. Малчдын худаг ус, бэлчээрийн даац, ахмадын эмнэлэг сувилал, айл гэрийг малжуулах гээд амьдралын жижиг сажиг асуудлаас эхлээд үндэсний түүх соёл, шинжлэх ухаан технологи, урлаг спорт гээд бүхий л салбарт хийсэн бүтээсэн шийдсэн, эхлүүлсэн, дуусгасан гэх сайн нэр, тод мөртэй.

23-хан насандаа Ахуйн үйлчилгээний яамны харьяа газруудын 3000 ажилтны цалинг бодож явсан энэ эдийн засагч гайхалтай сайн тооцоологч. Бээжингийн олимпийн алтан медалийн амжилтыг тооцоолсон учраас зүтгэсэн, хичээсэн, үр

дүн харагдсан. Үйл явдал, хурал, тайлангийн өмнө тэрбээр жижиг цаасан дээр тоо бичиж суудаг. Индэр дээр гарахад өнөөх код нь илтгэл, тайлан болж хувирна.

МАХН хүнд байх үед МАН-ын дарга М.Энхболд Н.Энхбаярыг урьж хамтдаа Эх орончдын баяраа тэмдэглэсэн. Шийдлийн Засгийн газарт нэгдэхэд тэр бусдын улс төрийн ашиг сонирхлын тооцоонос зөрж шийдвэр гарган нэгдсэн. Их аварга Д.Дагвадоржийг зодог тайлаад ирэхэд М.Энхболд гуайгаас өөр дарга тосч зорьж уулзаагүй. Тэр холч ухаантай, эв зеийг эрхэмлэдэг, манлайлагч улс төрч. Үзэлцэж ялан дийлэхээсээ илүү ярилцаж ойлголцож эргэцүүлэх боломжийг бусдад олгодог. Зөвлөн нь хатуугаа, идүүлсэн бут ургадаг, урсгал ус чулуугаа мөлийлгэж дийлдэг зэрэг амьдралаас урган гарсан ардын мэргэн үг түүний амьдралын философи.

Ярих уу, хийх үү энэ бол түүний уриа. Хийсэн болгоныг тоочиход хэвлэлийн хуудас, төлөвлөлт эвдэгдэнэ. Тоймлон онцлоход иргэд газраа өөрийн болгох ажлыг эхлүүлсэн, 1-5 дугаар ангийн хүүхдүүдийг Үдийн цайтай болгосон, Засгийн газрыг тэргүүлж байх үед цалин, тэтгэвэр гурав дахин өссөн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн. Тэр ярьдаг, уралцдаг, найруулдаг, хэлбэрддэг, хувирдаг чанараас ангид оршигч.

Тэр Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргаар таван жил, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны даргаар 11 жил, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны дарга, Үндэсний хөгжлийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн ахлагч, 40.000, 100.000 айлын орон сууц хөтөлбөрийн ажлын хэсгийн ахлагч зэрэг арав гаруй сонгуульт ажлыг гүйцэтгэсэн, гүйцэтгэж яваа. Мөн МАН-ын даргаар хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж буй нь бодит үнэлэмж. Улс төрийн тогоонд итгэж найдах эрхэм төлөөлөгч ховордсон энэ цагт тэр монгол төрийн нэгэн том тулгуур баагана, сүр хүч, итгэл найдвар харагдана.

Нугарашгүй бат, хугарашгүй бөх, хувирашгүй үнэн чанар. Тэр нэр хүндтэй, нүүр бардам амьдарч. Далайхад дальдрах, давшихад бултах шалтгаан байсангүй. Тэр үнэний замаар шударгаар алхаж, хорвоогийн жамтай наанатай, цаанатай амьдарч.



Нэг тийм, за гэвэл ёогүй төрх. Тэр улс төрд 20 гаруй жил зүтгэхдээ нэг л төрхөө дархалж чадсан. Савсганах, хэнхэглэх, амбийцлах, анхаарал татах, далимдуулах гэх мэт популистуудаас огт өөр. Хийчихлээ гэж цээжкээ дэлдэн бардамнасан нь үгүй, хэлүүлчихлээ гэж гомдлох нь харагдаагүй. Шийдэж чадсанаа зарлаагүй, шийдэж чадаагүйгээ нуугаагүй. Тэр аливаад голч, дүн нуруутай их уулс мэт дөлгөөн сур бараатай оршигч бас аврагч.

Дэлхийн дээд амжилтыг Монгол хүн морьтойгоо шинэчлэн тогтоох ажлыг санаачлан зохион байгуулсан. 11125 морьд жагсаж, 4249 морь уралдах тэр өглөө “Морь хүүхэд хоёр эсэн мэнд байгаасай” гэж хоёр цаг бурхандaa залбираад ирлээ гэж санаашран өгүүлснийг нь түмэн мартаагүй.

Их мөрөн мэт дөлгөөн энэ эрийн зүрх шаналж, сэтгэл нь өвддөг байна, бас. ■

**ТЭР АЛИВААД
ГОЛЧ, ДҮН
НУРУУТАЙ
ИХ УУЛС МЭТ
ДӨЛГӨӨН СУР
БАРААТАЙ
ОРШИГЧ БАС
АВРАГЧ.**

М.ЭНХБОЛДЫН 2008-2016 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТҮҮВЭР ТОВЧООН

УИХ-ЫН гишүүн М.Энхболд жил бүр ажлын тайлангаа иргэд сонгогчиддоо хүргүүлдэг тул энэ удаад томоохон ажлуудыг тоймлон хүргэж байна.



**ХӨШИГИЙН ХӨНДИЙН
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**
Ерөнхий сайд байхдаа Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг японы хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн. Энэхүү томоохон бүтээн байгуулалтыг даган 30.4 км урт, 2 урсгал, 6 энээтэй монголын анхны хурдны зам баригдана.

1



**ЗАМЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТУУД ХИЙГДСЭН**
Налайх-Зуунмод чиглэлийн 25 км, Борнуур, Жаргалант, Батсүмбэр сумын 78.4 км нийт 103.4 км хатуу хучилттай зам ашиглалтад орж, Төв аймгийн Зуунмод хот 2 талаараа, Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумд Улаанбаатар хоттой, мөн Эрдэнэ, Баян, Баяндэлгэр сумд аймгийн төв Зуунмод хоттой хатуу хучилттай автозамаар холбогдоло.

2



ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ
2009-2011 онд хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсний дагуу Зуунмод суманд 20 айл, 38 айлын орон сууц, хуульчдын хоткон ашиглалтад орж, төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөнгөлөлттэй зээлд хамруулнаар Зуунмод сумын иргэдийг орчин үеийн тохилог орон сууцаар хангах ажлын эхлэлийг тавьсан.

3



**СПОРТ ЦОГЦОЛБОРЫН
БАРИЛГА**
Төв аймаг төдийгүй төвийн бүсийн аймгуудын спорт, урлаг соёлын арга хэмжээнүүд зохиогддог томоохон төв болоод байна. Урлаг соёлын олон алдартныг төрүүлсэн Төв аймгийн драмын театрин барилга 1962 онд ашиглалтад орсон түүхтэй. Тэгвэл одоо орон нутаг дахь хамгийн том театр Зуунмод хотноо сундэрлэж бүтээн байгуулах ажил 50 хувьтай явна.

4



**ТӨВ НУТГИЙНХНЫ
ХҮСЛИЙН БАЯР
“АЛТАН ШАНАГА”**
2008 оноос эхэн жил бүр шинэ жилийн баярын “Алтан шанага” цэngүүний зохион байгуулж Төв аймгаас төрсөн алдар цолтон, авьяас билигтэн, амжилт бүтээлзэр дүүрэн яваа залусаас оны шилдгүүдийг алдаршуулан шагнаж улмаар Монгол түмэндээ танилцуулж ирлээ. “Алтан шанага” өнөөдөр Төв нутгийнхны хүсэн хүлээдэг баяр болжээ.

5



**132 ГҮНИЙ ХУДАГ,
260 ӨРХ МАЛТАЙ БОЛОВ**
2009-2011 онд “гишүүний тэрбум”-аар Төв аймагт 132 инженерийн хийцтэй гүний худаг гаргаж үлдсэн хөрөнгөөр аймгийн нэгдээн эмнэлгийн их засвар, сумдын сургууль, цэцэрлэгийн барилгын ажлуудыг санхүүжүүлсэн. 2011 онд 26 сумын 260 өрхийг хамруулсан малжуулах төсөл хэрэгжүүлэн, 2600 төлөг, 1820 борлонг малчид иргэддээ буцалтгүй тусламжаар олгосон.

6



**ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААНЫГ
АШИГЛАСАН НЬ**
2012 онд газрын гүний дулааныг ашиглан барилга байгууламжийг халаах инженерийн туршилтыг Монгол Улсад анх удаа Төв аймгийн Зуунмод суманд хэрэгжүүлж, Зүндэлгэр багийн цээрлэг, сургуульд ашиглаж жилд халаалтын зардалд 130-160 сая төгрөг хэмнэж байна.

7



**ХҮЙТЭН ӨВЛИЙГ
ИРГЭДТЭЙГЭЭ ХАМТ**
Өвөлжилт хүндэрч болзошгүй байсныг харгалзан 2015 оны 11 дугээр сард тал хээрийн бүсийн сумдад “Тэр дулаан бол сэтгэл дулаан төсөл” хэрэгжүүлэн 1800 тонн нүүрсийг 14 сумын 2000 орчим айлд, түүний дотор Зуунмод хотын 500 орчим айлд олгосон.

8



**ГИШҮҮНИЙ
ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ
АХМАДУУДАД**
2012 оны гишигийн нэг тэрбум төгрөгөөр Баруун Зуунмодын аманд ахмадын сувилал байгуулсан. Нэг удаад 30 орчим ахмадыг хүлээн авдаг.

9



ӨНӨӨДРИЙН УЛААНБААТАРЫН БАТ СУУРИЙГ...

М.Энхболд 1999-2005 онуудад Нийслэлийн Засаг даргаар ажиллаж байхдаа “Нийслэл хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулсан. Улаанбаатар хотод жилд дунджаар 10 мянган өрх айл ирж суурьшдаг байсан бол 2000 оны эхээр 50 мянга болсон нь ирээдүйгээ төлөвлөх, бүгдийг ултай тооцож, дэд бүтцийн суурийг нь баттай тавих алсын харааг шаардаж байлаа. Ингээд гурван жилийн турш махран боловсруулсан “**Нийслэл хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө**”-гээ 2005 онд танилцуулсан нь үе үеийн Хотын дарга нарын ширээний ном, баримтлах зарчим болж чадсан юм.

Дараа дараагийн хотын удирдлагууд энэхүү төлөвлөгөөний дагуу ажилласан, ажиллаж байгаа нь Ерөнхий төлөвлөгөөг харахад тодорхой болдог.

Төлөвлөгөөний оршилд бичсэн “**2020 онд нийслэлийн хүн ам алслагдсан дүүргийг оруулаад 1 сая 650 мянга хүрнэ**” гэсэн нь анхаарал татна. Одоо манай хүн амын 40 гаруй хувь нь Нийслэлдээ суурьшаад байна. М.Энхболд дарга бодитой төсөөлөл, нарийн тооцооллыг **11 жилийн өмнө хийж чаджээ**. Тодруулбал, энэ ерөнхий төлөвлөгөө хэтдээ хүн ам нь эрс нэмэгдэх Улаанбаатар хотын дэд бүтцийн суурийг М.Энхболд дарга алсын хараатай тавьж өгч чадсаныг батлан харуулж байна. Төлөвлөгөөнд Хөшигийн хөндийн Олон Улсын нисэх онгоцны буудлын төлөвлөгөөтэй уялдуулж Буянт-Ухаа хорооллыг байгуулж, “**соёл ахуй үйлчилгээний хөгжингүй төв болно**” хэмээсэн байна. “Олон улсын нисэх онгоцны буудал, Улаанбаатар хотыг холбосон хурдны зам өнгөрөх тул энэ хорооллын архитектур

– орон зайн төлөвлөлт зохиомжийг **өндөр төвшинд боловсруулна**” хэмээн тов тодорхой зааж өгчээ. Буянт-Ухаа хороолол одооныхоосоо ч илүү тэнэ гэдэг нь энэхүү баримт бичгээс харагдана. Мөн “**Гандан, Зурагт, Дэнжийн мянган, Наран, Зуун айл гэх мэт хотын төвд ойр гэр хорооллыг орон сууцжуулна**” хэмээн Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг төлөвлөн баталж ингэснээр утас, хөрсний бохирдолс салж чадна гэдгийг тухайн үед тооцоолсон байна.

М.Энхболдыг хотын дарга байх хугацаанд **5120 айлын орон сууц ашиглалтад орж, 1000 оюутны байр барьж, 6 цэцэрлэгт хүрээлэн байгуулагдсан**. Мөн иргэнд газрыг өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 32.3 мянган өрх газраа өмчилж авсан нь ирээдүйд ч үр жимсээ өгөх далайцтай ажил болсон. Хэтдээ цахилгаан, усны асуудал нэмэгдэнэ гэдгийг зөв тооцсон учир тухайн үед **10 мянган** өрх айл шинээр цахилгаан эрчим хүчээр хангаждаж, Нийслэлийн үндны эх үүсвэр Туул, Улиастай, Гачуурт голын ус хураах талбайг хамарсан **11.6 мянган га газрыг Нийслэлийн тусгай хамгаалалтад авчээ**.

“Ирээдүйд ямар байдалтай баймаар байна, өнөөдрөөс хийж эхэл” гэсэн үг бий. Тэрбээр цахилгаан, дулааны станц, цэвэр усны эх үүсвэр, үерийн далан хаалтууд, инженерийн шугам сүлжээ зэргийг дүүрэг дүүргээр нь нарийвчлан зааж өгчээ. 2005 онд 57500 байсан авто хэрэгслийн тоо **2020 онд 144 мянга болж нэмэгдэнэ** гэдгийг хүртэл төсөөлж, замын масштабыг нарийн төлөвлөсөн байна. М.Энхболд бол аргагүй л алсын хараатай улс төрч бөгөөд Улаанбаатар хотын суурийг ийнхүү бат сайн тавьж өгч чаджээ.



**... ДАРАА
ДАРААГИЙН
ХОТЫН
УДИРДЛАГУУД
ЭНЭХҮҮ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ДАГУУ АЖИЛЛАЖ
БАЙНА.**

БИ БОЛДООГООР БАХАРХДАГ

М.Энхболдын гэргий Ж.Туяацэцгэй ШУТИС-ийн харьяа Үйлдвэрийн технологийн сургуулийн захирал, доктор, профессор энэ хатагтай ШУТИС-д 26 дахь жилдээ сургалтын мастер, багш, бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирлын албыг хашиж явна. Тэр МУ-ын зөвлөх инженер хүн. Энэ удаа бид төрийн түшээгийн гэргийн амьдралын түүх хүүрнэлээс онцлон хүргэхээр бэлтгэсэн нь энэ.

► ДУГУЙ ЦАГААН ОХИН

Миний өвөө Сүхбаатар Хатанбаатар Магсаржавын цэрэгт орчуулагч хийж баруун хязгаарыг төвхнүүлэхэд гар бие оролцож явсан тухай “Ардын журамт цэргийн дурдатгалууд” номд бичигдсэнийг бага байхдаа уншаад бахархах сэтгэл төрж билээ. Өвөө зэгсэн боловсролтой орос хэлэнд төгс сайн, хятад хэл гадарладаг хүн байсан учраас Оросхүү гэж нэрлэдэг байнсыг хожим мэдсэн. Ардын журамт цэргийн партизаны үнэмлэх нь одоо Ховд аймгийн музейд бий. Харин аваын аав адуучин Баатар гэж хүн байж, их олон адуутай. Бидний аль аль талын эмээ, өвөө нилээд эрт бурхан болсон болохоор зургаар нь аавын ээж, ээжийн аав гэж ярьдагсан. Миний хүүхэд насны амьдрал тэр үеийн олон хүүхдтэй айлуудын жишгээр л өнгөрсөн дөө. Бид ээжээсээ наймуулаа. Хоёр маань бурхан болсон. Гурван эгч, хоёр дүүтэй. Багадаа “дугуй цагаан хүүхэд, хөөрхий минь” гээд эвийлчихээр үйлчихдаг охин байсан гэдэг. Аав минь аграномч, ээж банк санхүүгийн мэргэжилтэй.

Сурагч байхдаа алгебр, геометр, шугам зургийн хичээлд жигтэйхэн сонирхолтой, заримдаа ангийнхныхаа гэрийн даалгаврыг хийж өгнө. Олон хүүхдийн шугам зургийг зурж өгсөн дөө. Инженер болох нь миний багын мөрөөдөл юм. Харин манай Болдоо их нийтэч олонгийгоо хүүхэд байсан. Бид хоёр есдүгээр ангиасаа үерхэж сургуулиа төгсөөд айл гэр болсон доо. Ер нь нэгдүгээр сургуулийн 1982 оны төгсөлтөөс нэлэнэн хэдэн хос төрсөн юмдаг. Анхны хүүхдээ тээж аав, ээж болох бэлтгэлээ хийж байсан үеэ эргээд дурсахад сайхан байдаг. Хүүхдийнхээ хүйсийг нь урьдчилан мэдэх боломжгүй үе л дээ. Тэгээд хүү төрөхөд Болдоо маань маш их баярлаж билээ. Өөрөө айлын ганц хүү болохоор, анхны минь хүүхэд хүү төрлөө гээд л. Би төрөхийн өмнө их хордолго өгч хавагнадаг учраас урьдчилж хэвтдэг. Охиноо төрөхөд нэлэнэн хэд хоног хэвтсэн, манайхан өдөр бүр л эргэж очно. Тэгсэн битүүний


оройноос өвдөж эхэллээ. Гэрийнхнээ сандаргаад яхав гээд хэлээгүй. Шинийн нэгний өглөө найман цагт төрчихлөө. Төрөх тасгийн утсаар гэр рүүгээ ярьтал “за яж байна чимээ байна уу” гэнэ. Би “төрчихсөн” гэхэд итгэдэггүй. Охинтой болсон гэсэн чинь шуугилдаад бөөн баяр болцгоож билээ. Энэ цагаас хойш бид гучин хэдэн жилийг хамтдаа туулжээ. Манайхан чинь бүгдээрээ хөдөө амьтай улс. Болдоо хүүхэд байхдаа амралт болгоноор хөдөө авгууд руугаа явдаг байсан. Би Миеэгомбо гэдэг айлд бэр болоод л хөдөөгийн амьдралын сайн сайхынг мэдэрч татагдаж эхэлсэн. Анарыг төрөөд сар ч болоогүй байхад л хөдөө гарч билээ. Малчин түмний амьдралд орж үнээ, гүү сааж, айраг цагаагаа боловсруулж, гэдэс арилгаж сурсан. Мааньт хайрхан, Баян хайрхан, Өлзий өндөр, Гэр овоо, Хадат, Төмстэй, Налгай, Ар цагаан, Өвөр цагаан, Авгайт, Ант гээд л сайхан тал нутгаар очиж алжаал тайлан амрах хичнээн сайхан гээч.



2008 оны 7 дугаар сар. Гэр бүл болсныхоо 25 жилийн ой, мөнгөн хуримын үеэр хүү охин хоёрын хамт.

► **БИД ХОЁР ЕСДҮГЭЭР АНГИАСАА ҮЕРХЭЖ СУРГУУЛИА ТӨГСӨӨД АЙЛ ГЭР БОЛСОН ДОО.**





► БИ БОЛДООГООР БАХАРХДАГ

Зөв бодолтой, зөв үйлтэй, шударга, зарчимч байх буюу “хүн” байх утга учрыг би ханиасаа дандаа мэдэрдэг. Ханьдаа гэргийн ёсоор хазайхад нь түшиг болж, сэтгэл гундуу үед нь дэм болж явах үүрэгтэй. Нөхөр маань хотын дарга, ерөнхий сайд, шадар сайд гээд хариуцлагатай албан тушаалыг хашиж улс орны хүнд хэцүү сорилт тулгарсан асуудлууд, халдварт өвчин, ган, зуд, үер ус гэх мэт хүнээс арга эв, зохион байгуулалт тэсвэр тэвчээр шалгасан олон ажилд оролцож, биечлэн удирдаж явна. Цаг завгүй зүтгэж, нойр хоолгүй явж улс орон, хүн ардынхаа төлөө хэрэгтэй үед нь өөрийгөө зориулж чадаж байгаагаар нь би баходраг. Аливаа хүний зан чанар нь өсөх наснаас тогтсон гэр бүлийн хүмүүжилтэй салшгүй холбоотой юм даа. Хүмүүс эхлээд манай хүнийг их сурдмээр, их зантай гэдэг юм. Гэхдээ танилцаад, харьцаад ирэхээрээ өөр л дөө. Амьдрал дээр их зөвлөн хүн шүү дээ. Нямбай, цэвэрч, эмх цэгцтэй, ажилсаг, гэр амьтай, хүний өөрийн гэлтгүй хүүхдэд маш хайртай, хүүхэд, хөгшид, өвчтэй зовсон хүнийг асарч халамжахдаа эвлэг, хүнийг том, жижиг, дээд, доод тушаалын гэж ялгадаггүй, ямар ч хүнтэй үг яриа нийлдэг, нийтэч, шударга бус зүйлд хатуу. Бид хамт амьдраад одоо 32 жил болж, яг л нэг хүн шиг болдог юм байна. Баярлахаараа яадаг, уурлахаараа яадаг, хэзээ юу идэх дуртай, ядарсан, сэтгэл санаа тавгүй үед нь ях вэ гээд л. Манай Болдоо сайхан хоол хийгээд гэр бүл ах дүүсээрээ ширээ тойрон сууж баяр жаргалаа хуваалцах маш дуртай. Хоол хийхдээ сайн, ямар ч тогоочийг дагуулахгүй амтлаг сайхан хоолыг хурдан хийдэг хүн дээ. Болдоо охинтойгоо, би хүүтэйгээ их аминчирхана. Би нөхрийгөө туршлагатай төрийн хүн төдийгүй маш сайн хань, сайн аав, сайн өвөө гэж хэлнэ.

► ХИЙГЭЭГҮЙ ҮЙЛДЛИЙН ТӨЛӨӨ ТҮҮНИЙГ ГҮТГЭХЭД ЭМЗЭГЛЭДЭГ

Зарим хүмүүс мөс чанараа алдаж байгаад их эмзэглэх юм. Эх орноо дээдэлдэг, ахас дээдэс, үр хойч, найз нөхдөө эрхэмлэн хүндэлдэг, ёс жудгаа алдаж байгаад санаа зовохгүй байхын аргагүй. Монгол монголоороо байж эрүүл саруул, энх тунх, эвтэй найртай, эрч хүчтэй, ирээдүйдээ итгэл дүүрэн амьдрах цаг үе ирнэ гэдэгт итгэдэг. Болдоогийн хажууд 32 жил амьдраадаа би түүнийг өөрөөсөө ч илүүтэй мэдэх болж. Заримдаа хийгээгүй үйлдэлд эзэн болгож түүнийг гүтгэхэд их эмзэглэдэг. Тэр хүний үнэнч, тууштай, шударга занг мэддэг учраас өөрт нь ямар хэцүү байгаа бол гэж бодохоор хэцүү санагддаг. Тэр бол түшигтэй хань, сайн аав, хүнлэг, зарчимч иргэн. Хүн байх учир нь “эрүүл саруул байж, хүнлэг энэрэнгүй аливаад чин сэтгэлээсээ хандаж, юмыг сайхнаар бодож, бие биедээ итгэл, сэтгэл хайлладаг, зөв үйлстэй байх ухаан” гэж бид үздэг.





Монголчууд Гиннесийн дэлхийн дээд амжилтыг хоёр төрлөөр эзэмшиж байна



4249 хурдан морины уралдаан



11125 морьтны их жагсаал

ЭРХЭМ ТҮШЭЭ БА МОНГОЛ МОРЬД

Түүнийг морь, түүнийг дагасан өв соёлоос салгаж ойлгох аргагүй. Хүүхэд байхдаа зуныхаа амралтаар аавынхаа дүү нарынд очиж хөдөөний амьдрал дунд гурван сар бужигнаад божийсон борхүү гэртээ эргэж ирнэ. Хурдан морь унах хорхой, хүсэл дүүрэн ч хүнддээд унуулдаггүй байсан тухай хожмоо дурссан удаатай. Адууны хээр, зээрд зүсийг өөртөө ээлтэй гэж билэгшээдэг. Анх ах нь хар голтой хул морь бэлэглэж адуутай болох суурийг тавьсан. Одоо улс бүсийн наадамд айрагдсан гялгар хул, аман хүзүүдсэн өвгөн хээр азарга, улс бүсийн наадамд айрагдсан зээрд халzan морь гээд зүс зүс, нас наасны морьдтой.

2008 оноос хойш Монголын морин спорт, уяачдын холбооны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв. 1995 оны хавар Төв аймгийн Баянжаргалан суманд адуучны отрын гэрт манай улсын нэр бүхий морины зүтгэлтнүүд тус холбоог байгуулах



Гиннесийн дэлхийн дээд амжилт, 11125 морьтны жагсаалд



**АЖЛЫНХАА ЧӨЛӨӨГӨӨР
БОЛОМЖ Л ГАРВАЛ
ХӨДӨӨ ГЭР ЛҮҮГЭЭ
ХЭДЭН АДУУ РУУГАА
ЖОЛОО ЗАЛНА.**

анхны яриаг эхлүүлсэн түүхтэй. Ноён М.Энхболд тус холбооны ерөнхийлөгч, моринд амьтай Монгол эрийн хувьд ММСУХ-ны 20 жилийн ойг тулгын чулуугаа тавьсан Сайн хөөтийн Адуун чулуу гэдэг газар хөшөө босгож найман насны морь уралдуулж томоохон баяр наадам зохион байгуулсан. Ер нь тэрээр өнгөрсөн хугацаанд ММСУХ-г Азийн морин уралдааны холбоо, Дэлхийн морин уралдааны холбоонд гишүүнээр элсүүлж, уяачдыг бүртгэлжүүлэх, хөдөлмөрийг нь үнэлэх, уралдаанч хүүхдэд спортын цол олгох зэрэг олон ажлуудыг хийсэн. Мөн хүүхдийн хамгаалалтын хувцас хэрэглэлийн стандарт батлуулах, хүүхэдгүй уралдсан морийг таван байраар ухраах, монгол эрийн морьдыг тусад нь уралдуулах зэрэг олон ажлыг санаачлан хэрэгжүүлснийг дуулгахад таатай байна.

Түүний санаачилгаар Хубилай хаан 1263 онд

төрийн тогтолцоондоо Адууны яам байгуулсан түүхт 750 жилийн ойг тохиолдуулан 4249 хурдан морины уралдаан, 11125 морьтны их жагсаал зохион байгуулж Гиннест Монгол улс дэлхийн дээд амжилтыг хоёр төрлөөр эзэмших болсон юм.

М.Энхболд одоо ч ажлынхаа чөлөөгөөр боломж л гарвал хөдөө гэр лүүгээ хэдэн адуу руугаа жолоо зална. Аргалын утаа, адууны хөлс үнэртсэн хөдөөд нутгийн буурлуудтай хөөрөг зөрүүлэн хуучлах нь төрийн түшээд бөөн олз омог, бахархал мөн таатай сайхан агшнууд.

Морин дэл дээрээсээ дэлхийн талыг эзэлж Их Монгол улсаа байгуулж явсан аархам түүхтэй морьтон үндэстнийхээ өмнө тэрбээр төрийн түшээгийн хувьд ч, монгол эрийн хувьд ч үүргээ өндөрөөр биелүүлж монголын хурдан морины түүхэнд онцгой үйл явдлуудыг “бэлэглэж” байна. ■